



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 13

Хэрлэн сум

ХIII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын ХIII хурал 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 17:00 цагт аймгийн Засаг даргын хуралдааны танхимд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Сүүлийн өдрүүдэд БНСУ, Япон, Итали зэрэг улсад шинэ коронавирусийн халдварын өвчлөлийн тохиолдлын тоо эрс нэмэгдэж, Монгол улсын Засгийн газраас тус улсуудад нислэг үйлдэхийг зогсоох шийдвэр гаргасантай холбогдуулан дээрх улсуудад байгаа манай улсын иргэд ОХУ-аар дамжин Эх орондоо ирэх эрсдэлт нөхцөл байдал үүсээд байна.

Иймд ОХУ-тай холбогддог олон улсын Эрээнцав-Соловьевск боомтын мэргэжлийн байгууллагуудын хүч, хэрэгслийг нэмэгдүүлэн, шинэ коронавирусийн халдвараас урдчилан сэргийлэх арга хэмжээг өндөржүүлж ажиллах шаардлагатай байгаа тул Монгол улсын Засгийн газрын нөөц хөрөнгөөс хуваарилагдаж байгаа нэг удаагийн хувцас, хэрэглэл, амны хаалт, ариутгалын бодисоор хангах ажлыг шуурхай зохион байгуулж дэмжлэг үзүүлэх,

2. Авто замын Ульхан-Верхний Ульхун хилийн боомтын үйл ажиллагааг түр хугацаагаар хаах саналыг Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Монгол улсын Шадар сайд, улсын Онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар нарт хүргүүлэх зэрэг асуудлыг онцгой комиссын гишүүд хэлэлцэв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Онцгой комиссын гишүүн, Мэргэжлийн хяналтын газрын дарга, Д.Мөнхтуяа, Онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн газрын дарга, Ч.Оюунаа, Хилийн 0275 дугаар ангийн захирагч, хурандаа Б.Гантөгсөд

1. ОХУ-тай холбогддог олон улсын Эрээнцав-Соловьевск боомтын мэргэжлийн байгууллагуудын хүч, хэрэгслийг нэмэгдүүлэн, шинэ коронавирусийн халдвараас урдчилан сэргийлэх арга хэмжээг өндөржүүлэн Монгол улсын Засгийн газрын нөөц хөрөнгөөс хуваарилагдаж байгаа нэг удаагийн хувцас, хэрэглэл, амны хаалт, ариутгалын бодисоор хангах ажлыг шуурхай зохион байгуулах,

Хоёр. Онцгой комиссын гишүүн, Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Б.Алтансүхэд

1. Авто замын Ульхан-Верхний Ульхун хилийн боомтын үйл ажиллагааг түр хугацаагаар хаах саналыг боловсруулан Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Монгол улсын Шадар сайд, улсын Онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар нарт хүргүүлэхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА



М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРВИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Д.БАТТУЛГА